





САНХҮҮГИЙН ҮР ДҮН,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2025 ОНЫ II УЛИРАЛ

7-P CAP, 2025



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЭЗ ӨСӨЛТ




МӨНГӨНИЙ БОДЛОГО

Инфляцын түвшин 6-р сард 8.2 хувьтай гарсан ба импортын барааны үнийн нөлөө 2.4 нэгж хувийг бүрдүүлжээ. Харин барааны бүлгээр орон сууц, цахилгаан, түлшний үнийн өсөлт 2 хувийг, хүнсний ус, ундааны үнийн өсөлт 1.6 хувийг бүрдүүлсэн байна. ХҮИ сагсны 55.3 хувийг нь импортын бараа бүтээгдэхүүн эзэлж байна.



ГВАН






ХАНШ



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ


ГАДААД ХУДАЛДАА

КОКСЖИХ НҮҮРС
сая тоннХИЛИЙН ҮНЭ
usd / тоннЭКСПОРТ, ИМПОРТ ӨСӨЛТ
жилийн өсөлт


ГАДААД ХУДАЛДААНЫ БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

КОКСЖИХ
НҮҮРС
2.6 тэрбум.\$
-44%ЗЭС
2.3 тэрбум.\$
61.7%АЛТ
412 сая.\$
-15.7%ЭКСПОРТ
6.6 тэрбум.\$ИМПОРТ
5.5 тэрбум.\$ЭКСПОРТЫН
ӨСӨЛТ
-17%ИМПОРТЫН
ӨСӨЛТ
3%ХУДАЛДААНЫ
ЭРГЭЛТ
12.1 тэрбум.\$ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ
1.1 сая.\$ТҮЛШ
983 сая.\$
-7.3%АВТОМАШИН
668 сая.\$
45%ХҮНД ДААЦЫН
МАШИН
293 сая.\$
-13.2%

Импорт, улсаар, 2025Q2



Экспорт, улсаар, 2025Q2



ГОЛОМТ БАНК

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



THE BANK OF NEW YORK MELLON CORPORATION - ТЭЙ ХАМТРАН УЛААНБААТАР ХОТНОО ХОЁР ДАХЬ УДААГАА КОМПЛАЕНСИЙН СЕМИНАРЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Энэхүү арга хэмжээнд зохицуулагч байгууллагууд, BNY-ийн төлөөлөгчид, Монголын банк санхүүгийн салбарын Комплаенсийн мэргэжилтэн, ажилтнууд зэрэг 100 гаруй зочид төлөөлөгчид оролцов.



ГОЛОМТ БАНК ОУ-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДААС 21 САЯ АМ.ДОЛЛАРЫН УРТ ХУГАЦААТ САНХҮҮЖИЛТ ТАТАВ

Энэхүү санхүүжилтийг бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийнхээ санхүүгийн хэрэгцээг дэмжих, зээлийн хүртээмжийг сайжруулах, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор харилцагчдадаа олгоно.



ГОЛОМТ БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ 2025 ОНЫ 4-Р САРЫН 17-НД БОЛЛОО

Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-н тав дахь Хараат бус гишүүн Сингапур улсын иргэн Ноён Ронил Сүжан шинээр томилогдсон билээ. Ингэснээр Голомт Банкны ТУЗ-ийн 9 гишүүдээс 5 хараат бус гишүүдээс бүрдсэн ба энэхүү үйл явдал нь ТУЗ-ийн хараат бус шийдвэр гаргалт, зохистой засаглал, хариуцлагатай байдлыг улам бататгаж, урт хугацаанд тогтвортой ашигтай үйл ажиллагааны баталгаа болж байна.



ГОЛОМТ БАНК 30 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭГЭЭ ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТ ТЭМДЭГЛЭЛЭЭ

Голомт банкны 30 жилийн ойн баярыг тохиолдуулан банкны Топ харилцагчдын арга хэмжээг 6 сарын 18-ы өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд гадаад, дотоодын 303 корпорейт компанийн эзэд, захирлууд, элчин сайдын яамд, төрийн байгууллагын төлөөлөл хүрэлцэн ирж банкны 30 жилийн түүхэн өсөлтөд оруулсан хувь нэмрээ тэмдэглэлээ.



БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН "SHELEADS" АРГА ХЭМЖЭЭГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Арга хэмжээний үеэр эдийн засгийн хөгжилд үзүүлэх эмэгтэйчүүдийн нөлөөлөл, оролцоог нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн сургалт, илтгэлүүд тавигдаж бизнес эрхлэгч эмэгтэйчүүд өөрийн сайн туршлага, түүхээсээ хуваалцаж, нээлттэй хэлэлцүүлгийг өрнүүллээ.



"MONGOLIA INVESTMENT FORUM: NEW YORK 2025" ЧУУЛГЫН ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР АЖИЛЛАЛАА

АНУ-ын Нью-Йорк хотод зохион байгуулагдсан "Mongolia Investment Forum: New York 2025" хөрөнгө оруулалтын чуулгын ерөнхий ивээн тэтгэгчээр Голомт банк ажиллаж, Гүйцэтгэх Захирал А.Одонбаатар "Financing Mongolia's Future: Debt Market Dynamics and Credit Rating" хэлэлцүүлэгт панелистаар оролцлоо.



2024 ОНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАНГАА НИЙТЭЛЛЭЭ

Банк өөрийн үйл ажиллагааны хүлэмжийн хийн ялгарлыг 2023 оноос 56%-иар буурууллаа. Мөн өөрийн үйл ажиллагаа болон санхүүжилтээр дамжуулан, ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлыг 2030 онд 30%-иар 2050 онд 50%-иар бууруулах зорилт тавин ажиллаж байна. Банк тайлант онд нийт ₮390 тэрбумын тогтвортой, ногоон санхүүжилтийг олгож, ногоон зээлийн багцаар дамжуулан нийт 4,700 гаруй ажлын байр, 99 тэрбум төгрөгийн нэмүү өртгийг бий болгов.



ГОЛОМТ БАНК НЬ ISO/IEC 27701:2019 СТАНДАРТЫН ГЭРЧИЛГЭЭГ АВЧ, ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГОО БАТАЛГААЖУУЛЛАА

Тус стандарт нь ISO/IEC 27001 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн системийг өргөтгөсөн хувилбар бөгөөд хувь хүний мэдээллийг хамгаалах, боловсруулах, хадгалахтай холбоотой олон улсын шилдэг туршлагаудыг хэрэгжүүлдэгийг гэрчилдэг.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД



Голомт банк хүүхэд, залуусын сайн дурын ажлыг дэмжих хөтөлбөр эхлүүлээ. Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд Голомт банк санаачлан хэрэгжүүлж буй "Eco Volunteer" хөтөлбөрийн дагуу Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах зорилгоор 80 гаруй хүүхэд Баянзүрх дүүрэг дэх Туул голын ай сав газарт цэвэрлэгээ хийж, орчны бөхирдлыг буурууллаа.



Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дараагийн шатанд гаргахад нь чадавхжуулах зорилготой MENTORSHIP 2024 хөтөлбөр хаалтаа хийж 52 харилцагчид сургалт зөвлөх үйлчилгээндээ бүрэн хамрагдаж дууслаа. 2025 оны менторшип хөтөлбөрт 100 харилцагч хамрагдаж эхэллээ.



Голомт банк эх орныхоо тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах, боловсролыг дэмжих зорилгоор их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, оюутнуудыг ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрөөс гадна дадлагажигч хөтөлбөр зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг ба энэ удаа "Мандах 2025" буюу "Салбар дундын судалгаа болон тогтвортой хөгжил" сэдвээр зохион байгуулагдсан ОУ-ын эрдэм шинжилгээний хурлыг ерөнхий спонсороор хамтран ажиллаа. Уг эрдэм шинжилгээний хурал Монгол, Тайланд, БНСУ, Казакстан, Англи, Австрали болон Энэтхэг улсын эрдэмтэн судлаачид оролцов.



Голомт банкинд Зүрх мартаггүй төслөөс талархал гардууллаа. Төрөлхийн зүрхний гажигтай, ховор оноштой хүүхэд багачуудыг Монголдоо оношлон, мэс засал хийж, бяцхан зүрхнүүдийг аврах зорилготой энэхүү төсөлд Голомт банк 2020 оноос хойш нийт 420 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллаа. Төслийн бүрэлдэхүүн одоогийн байдлаар Монгол Улсыг гурав бүтэн тойрч, 54,600 орчим хүүхдэд үзлэг оношилгоо хийж, 1,580 гаруй хүүхдэд амьдрал бэлэглэжээ.



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

UNIVERSE ШИНЭ КАРТУУДАА ТАНИЛЦУУЛЛАА



Голомт банк нь энэхүү хязгааргүй, харанхуй мэт боломжийн үүд хаалгыг нээхэд тань туслах "ил тод" болон "цаг хугацаа, орон зайнаас үл хамаарсан" экосистемийг бүрдүүлнэ.



Нээлттэй

Голомт банк IPO гарган олон нийтэд нээлттэй болсноор компанийн тайлан, тооцоо, үйл ажиллагааны мэдээллийг зах зээлд нээлттэйгээр танилцуулж байгаагаараа ил тод байна.



Тасралтгүй хөгжил

Технологийн давуу талыг ашиглан Голомт банк нь хил хязгааргүйгээр 24 цагийн турш таны туслах байна.



Орон зайнаас үл хамаарсан

Голомт банк нь Монголоос дэлхийн хамгийн олон картын брэндтэй хамтардаг бөгөөд та ажил, аялалдаа явахдаа картаараа хүссэн газраа гүйлгээ хийх боломжтой.






ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН НЭВТРҮҮЛЛЭЭ:


- Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зээл
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан шуурхай зээл
- Бүх төрлийн дотоодын шуурхай баталгаа
- ВЕКСЕЛ мөнгөжүүлэх үйлчилгээг банк санхүүгийн салбарт анх удаа
- CU сүлжээ дэлгүүрийн авлага барьцаалсан зээл

САНХҮҮ ҮР ДҮН


ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ




НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/
ЖДӨХ: 31% (2024-2022)




НИЙТ ЗЭЭЛ /тэрбум төгрөг/
ЖДӨХ: 39%




ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ /тэрбум төгрөг/
ЖДӨХ: 29%



ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/



ӨӨРИЙН ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/
ЖДӨХ: 23%




ДУНДАЖ ӨӨРИЙН
ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ (%)




ЗЭЭЛИЙН ЗАДАРГАА, ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН
/тэрбум төгрөг/




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХАРЬЦАА (%)




ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН САНГИЙН
ХҮРЭЛЦЭЭ (%)




БИЗНЕСИЙН ЗЭЭЛ
/тэрбум төгрөг/



ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ
/тэрбум төгрөг/



ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ
/тэрбум төгрөг/



2022

2023

2024

2025H1

2022

2023

2024

2025H1

2022

2023

2024

2025H1


ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ, ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НИЙТ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ
/тэрбум төгрөг/


■ Харилцах ■ Хадгаламж



ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР (%)




ЗАРДАЛ ОРЛОГЫН ХАРЬЦАА (%)




НИЙТ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ
/тэрбум төгрөг/


▼ 4.0%



ЗЭЭЛ, ХАРИЛЦАГЧИЙН ЭХ ҮҮСВЭР (%)




ДУНДАЖ АКТИВЫН ӨГӨӨЖ (%)




МОНГОЛБАНКНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (%)




ГАДААД ВАЛҮТЫН ЭРСДЭЛИЙН ХАРЬЦАА (%)



ХОЛБООТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ <20%



ХОЛБООТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ <5%



2022

2023

2024

2025H1

2022

2023

2024

2025H1



ТАНД БАЯРЛАЛАА

Холбоо барих: investornews@golomtbank.com